



БАТЛАВ:
ДИСПЕЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨХХК-
ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

 /Г.БАЛЖИННЯМ/



БАТЛАВ:
“ЖАРГАЛАНТ
ЭКСПЕДИТОР” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

 /Э.БОЛОР-ЭРДЭНЭ/



2022 оны 05-р сарын 09-ны өдөр

№62/2022

Улаанбаатар хот

Нэг талаас Диспетчерийн үндэсний төв /ДҮТ/ ТӨХХК /цаашид “Худалдан авагч” гэх/, түүнийг төлөөлж Зах зээл санхүү хариуцсан дэд захирал Ц.Өнөрмаа, нөгөө талаас “Жаргалант транспортны экспедитор” ХХК /цаашид “Худалдагч” гэх/, түүнийг төлөөлж Захирал ажилтай Э.Болор-Эрдэнэ /хамтад нь “Талууд” гэх/ нар нийлүүлэгчийн ирүүлсэн үнийн саналыг хүлээн зөвшөөрч, Монгол Улсын Иргэний тухай хуулийг удирдлага болгон ДҮТ ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны А/05 тоот тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хорооны 2022 оны 05-р сарын 04-ний өдөр Захиалагчид ирүүлсэн Шийдвэрийг үндэслэн Талууд дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэ ГЭРЭЭГ байгуулав.

Энэхүү гэрээ нь Худалдан авагч болон Худалдагчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Гэрээний агуулга

- 1.1. Энэхүү “Бичиг хэргийн материал худалдан авах” Багц-1:Бичгийн цаас худалдан авах гэрээнд заасны дагуу Худалдагч нь биет байдлын болон эрхийн доголдолгүй барааг бэлдэж Худалдан авагчид хүлээлгэн өгөх Худалдан авагч нь барааг хүлээн авч гэрээнд заасны дагуу төлбөрийг төлнө.
- 1.2. Барааны нэр, төрөл, үнийн жагсаалт, ажлыг хэсгийн шийдвэрийг Хавсралт-д заасан бараа материал.
- 1.3. Худалдагч бараанд холбогдох аливаа баримт бичгийг Худалдан авагчид барааг хүлээлгэн өгөх үед шилжүүлнэ.

2. Чанар

- 2.1. Худалдагчийн нийлүүлэх барааны чанар Монгол Улсад мөрдөгдөж буй чанар стандарт, худалдан авагчийн баталсан техникийн даалгаварын шаардлагыг хангасан байна.
- 2.2. Худалдагч барааны чанарыг худалдан авагчтай хамтран шалгана.
- 2.3. Баталгаат хугацаа гэрээний хугацаа дуусах хүртэл байна.
- 2.4. Худалдагч баталгаат хугацаанд барааны аливаа дутагдал доголдол, гэмтлийг арилгана. Аливаа гэмтэл дутагдал, доголдол илэрснээс хойш 3 хоногийн дотор мэдэгдэж заасан хугацаанд худалдагчид мэдэгдсэн бол өөр бараагаар солино.

3. Нийлүүлэх хугацаа, нөхцөл

- 3.1. Худалдагч нь гэрээнд заасан барааг худалдан авагчид захиалга бэлэн болсон нэн даруй худалдан авагчийн барааны агуулахад хүргэнэ.
- 3.2. Худалдагч гэрээнд заасан нийлүүлэлтийн хугацаанаас өмнө барааг нийлүүлэх эрхтэй бөгөөд ингэх тохиолдолд Худалдан авагчид нийлүүлэлтийн тухай мэдэгдсэн байна.

4. Үнэ төлбөр

- 4.1. Барааны нэгжийн үнэ болон нийт үнийг Хавсралт-д заасны дагуу мөрдөж ажиллана.
- 4.2. Гэрээгээр худалдах барааны нийт үнэ гэрээ дуусах хугацаа хүртэл **10,075,000.00 /Арван сая далан таван мянган/** төгрөг байна. Энэ үнэд НӨАТ орсон үнэ.
- 4.3. Худалдан авагч нь захиалсан барааг хүлээн авсан санхүүгийн баримтыг үндэслэн төлбөрийг 3 хоногийн дотор төлнө.
- 4.4. Үнэ нэмэх, валютын үнэ унах зэрэг энэхүү гэрээний нийт үнийг өөрчлөх үндэс болохгүй.

5. Сав баглаа боодол

- 5.1. Худалдагч барааг аюулгүй сав баглаа боодолд хийж, Худалдан авагч барааг хүлээн авах хүртэл гэмтэл эвдрэл, устахаас сэргийлж баталгаажуулна.
- 5.2. Сав баглаа боодлын үнэ барааны үнэд орсон болно.

6. Гэрээний хүчин төгөлдөр байдал

- 6.1. Энэхүү гэрээ талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Гэрээг 3 хувь үйлдэнэ.
- 6.2. Энэхүү гэрээ нь 2022-05-09-ний өдрөөс 2023-05-09-ний өдрийг хүртэл хүчинтэй байна.

7. Талуудын үүрэг хариуцлага

- 7.1. Гэрээг зөрчсөн тал нөгөө талдаа олох байсан орлогыг оролцуулан бүх холбогдох хохирлыг хуулийн дагуу төлнө.
- 7.2. Худалдагч гэрээний дагуу барааг хугацаанд нь нийлүүлээгүй бол хэтэрсэн хоног тутам 0,05 хувийн алдангийг худалдан авагч талд төлнө. Нийт алдангийн хэмжээ гэрээний үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй

8. Давагдашгүй хүчин зүйл

- 8.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл / тухайлбал : газар хөдлөлт, үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт / -ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

9. Маргаан шийдвэрлэх

- 9.1. Энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой аливаа маргаантай асуудлыг эвийн журмаар хоёр тал шийдвэрлэхийг хичээх бөгөөд хэрэв эвлэрэх боломжгүй бол Монгол Улсад мөрдөгдөж буй хуулийн дагуу шүүхээр эцэслэн шийдвэрлүүлнэ.

10. Талуудын хоорондох харилцаа

- 10.1. Талуудыг төлөөлж дараах этгээдүүдэд энэхүү гэрээтэй холбоотой асуудлаар харилцаа холбоо тогтоож, хэлэлцээ хийнэ:

Худалдагчийн төлөөлөгч: Э.Болор-Эрдэнэ
Албан тушаал: Захирал
Утас: 99097226, 77007725


Худалдан авагчийн төлөөлөгч: **Б.Ганцэцэг**
Албан тушаал: **Нярав**
Утас: **99062043**

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ЗАХ ЗЭЭЛ САНХҮҮ ХАРИУЦСАН ДЭД
ЗАХИРАЛ

  /Ц.ӨНӨРМАА/
ЗУА-НЫ ДАРГА

 /Б.БИНДЭРЪЯА/
СЭЗА-НИЙ ДАРГА БОГООД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ

 /Т.БЯМБАЖАВ/
ХУУЛЬЧ

 /Б.АНХЗАЯА/
ЗУА-НЫ ХУДАЛДАН АВАЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

 /Э.ӨЛЗИЙМАНДАХ/
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

 /С.НАМЧИНДОРЖ/

ХАЯГ:

Монгол Улс, Улаанбаатар хот 17060 Хан-
уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн Өргөн
чөлөө Засгийн газрын XIV байр 4,5 давхар
Утас: 7004 1371, 91177701
Факс: 7004 3467
Мэйл хаяг: Namchindorj.s@ndc.energy.mn



ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ЗАХИРАЛ

 /Э.БОЛОР-ЭРДЭНЭ/

ХАЯГ:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 9-р хороо,
Хоймор оффисс, 1002 тоот
Утас: +976 99097226, 77007725
Банк: Хаан Банк
Данс: 5009768397
Имэйл: jargalant.transport.export976@gmail.com



**ДИСПЕЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ**

17060 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
3-дугаар хороо, Засгийн газрын XIV байр
Утас: 7004-1315. Факс: (976) 7004-3467
E-mail: ndc@ndc.energy.mn

2022.05.05 № 01/698

танай _____ -ны № _____ -т

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Бичиг хэргийн материал худалдан авах багц-1 ДҮТ/202201031 тоот тендер шалгаруулалтын Үнэлгээний хорооны 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн шийдвэр дүгнэлтээр танай байгууллагын ирүүлсэн тендер "Хамгийн сайн" үнэлэгдсэн тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2 дахь заалтын дагуу гэрээ байгуулах эрх олгож байна

Иймд тендер хүчинтэй байх хугацаанд багтааж, гэрээ байгуулан хамтран ажиллана уу.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Г. БАЛЖИННЯМ

ТЕНДЕРИЙН МАТЕРИАЛ
ЭХ ХУВЬ“ЖАРГАЛАНТ ТРАНСПОРТНЫ
ЭКСПЕДИТОР” ХХКУлаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 9-р хороо, Хоймор
оффис, 1002 тоот
Утас: 99097226, 77007725

Мэйл хаяг: jarjalant_transport_export76@gmail.com

2022-04-20 № А/04-2001

Тайлбар -ны №

“ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ”-д

Тендерт оролцох хүсэлт

Манай компани нь 2015 оноос эхлэн гадаад, дотоод худалдаа, барилгын материалын худалдаа, уул уурхайн тоног төхөөрөмжийн худалдаа, бүх төрлийн бэлдэц төмрийн худалдаа, химийн бодис хадгалах, агуулах эрхлэх үйл ажиллагаа, хүнд механизмын түрээс, авто машиний сэлбэг хэрэгсэл зэрэг зуучлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж олон улсын стандартад нийцсэн, чанартай бараа бүтээгдэхүүн нийлүүлснээр захиалагчдынхаа талархалыг хүлээн ажиллаж байна.

Бид монгол улсын стандартад нийцсэн бүх төрлийн бараа бүтээгдэхүүн тоног төхөөрөмж сэлбэг, дагалдах эд ангиудыг ОХУ, БНСУ, АНУ болон БНХАУ-ын компаниудаас зуучлан импортлон худалдаж захиалчийн хүсэлт сонголтын дагуу шаардлагатай бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэн ажиллаж байна.

Манай “ЖАРГАЛАНТ ТРАНСПОРТНЫ ЭКСПЕДИТОР” ХХК нь танай байгууллагаас зарласан “БИЧИГ ХЭРГИЙН МАТЕРИАЛ” ДҮТ/202201031/03/01 дугаартай Нийт төсөвт өртөг нь: 28,042,000 төгрөгний тендер шалгаруулалтад өөрийн хөрөнгөөр 10,075,000.00 /Арван сая далан таван мянган/ төгрөгийн үнээр Олон улсын худалдааны DDP нөхцөлөөр “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн агуулахд 2 хоногт нийлүүлэх бүрэн боломжтой тул бидний хүсэлтийг хүлээн авч, тендерт оролцохыг зөвшөөрнө үү.

Тендерийн материалыг хавсаргав.

ХҮНДЭТГЭСЭН
ЗАХИРАГ

Э.БОЛОР-ЭРДЭНЭ



ГЭРЭЭ ДҮГНЭСЭН АКТ

2022 оны 05 дугаар сарын 13-ны өдөр

№62/2022

Улаанбаатар хот

Нэг. Гэрээ, гэрээний талууд

- 1.1. Гэрээний нэр, дугаар, огноо: "Бичиг хэргийн материал худалдан авах Багц-1:Бичгийн цаас худалдан авах" гэрээ, №62/2022, 2022-05-09
- 1.2. Диспетчерийн үндэсний төв ХХК /ДҮТ ХХК/, "Жаргалант транспортны экспедитор" ХХК хооронд 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан "Бичиг хэргийн материал худалдан авах Багц-1:Бичгийн цаас худалдан авах" гэрээний дагуу нийлүүлэх барааг бүрэн гүйцэтгэсэн тул Талууд энэ гэрээг дүгнэсэн актыг үйлдэв.
- 1.3. Гэрээнд заасан ажлыг хүлээн авсан ажлын хэсэг:
Захиалагчийг төлөөлж:

Б.Ганцэцэг

СЭЗА-ны нягтлан

Нийлүүлэгчийг төлөөлж: Э.Болор-Эрдэнэ

Захирал

Хоёр. Төлбөр тооцоо

- 2.1. Энэ гэрээний нийт үнэ нь **10,075,000.00 /Арван сая далан таван мянган/** төгрөг байна. Энэ үнэд НӨАТ орсон болно.
- 2.2. Гэрээгээр нийлүүлэх барааг бүрэн гүйцэтгэсэн тул Талууд бүрэн хүлээн зөвшөөрч төлбөрийг нийлүүлэгчийн ирүүлсэн нэхэмжлэх болон гэрээний гүйцэтгэлийг дүгнэсэн энэ актыг үндэслэн нийлүүлэгчийн харилцах Хаан Банкны 5009768397 тоот дансанд шилжүүлнэ.

Гурав. Дүгнэлт

- 3.1. "Жаргалант транспортны экспедитор" ХХК нь Захиалагчид гэрээгээр нийлүүлэх барааг бүрэн гүйцэтгэж, 2022 оны 05 дугаар сарын 13-ний өдөр төлбөрийн нэхэмжлэлийг ирүүлсэн.
- 3.2. **ГЭРЭЭНИЙ ДҮГНЭЛТ:** "Бичиг хэргийн материал худалдан авах Багц-1:Бичгийн цаас худалдан авах" гэрээний гүйцэтгэлийг Талууд 100 хувь гэж дүгнэсэн тул гэрээний 4.2, 4.3-д заасны дагуу гэрээний үнэ болох **10,075,000.00 /Арван сая далан таван мянган/** төгрөгийг нийлүүлэгчийн энэхүү гэрээ дүгнэсэн актын 2.2-д заасан харилцах банкны дансанд шилжүүлэхээр шийдвэрлэв.

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН:

ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ЗУА-ИЙН ДАРГА

СЭЗА-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ НЯГТЛАН
БОДОГЧ

ЗУА-НЫ ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

НИЙЛҮҮЛЭГЧ:

ЗАХИРАЛ

/Э.БОЛОР-ЭРДЭНЭ/

/Г.БАЛЖИННЯМ/

/Б.БИНДЭРЪЯА/

/Т.БЯМБАЖАВ/

/Э.ӨЛЗИЙМАНДАХ/

/С.НАМЧИНДОРЖ/

